# ДОРНОД АЙМГИЙН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2014.11.10 Дорнод аймаг

| Дэд хэсэг | Хийх ажлын агуулга | Тайлбар | |
|---|---|---|---|
| | | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ |
| 7.1.1 | Авлигын эсрэг хууль тог-тоомжийг иргэдэд сурталч-лах, энэ талаархи мэдээл-лийгиргэд,байгуулл ага чө-лөөтэйавах нөхцөлийг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хууль<br>5 дугаар зүйлийн 5.1.2;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; | Авлигын эсрэг хууль тог-тоомжийг боломжит хэлбэ-рээр сурталчлах /мэдээл-лийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа та-ниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэв-лэмэл материал г.м/ | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахтай холбогдуулан аймгийн 14 сум, 22 агентлагийн эрх бүхий албан тушаалтанд сургалт хийж гарын авлага болон холбогдох мэдээллээр хангаж ажилласан. 2013 оны хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Гаалийн газар, Байгаль орчны газрын нийт 133 мэдүүлэг гаргагч нарт сургалт зохион байгуулсан. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар хамтран аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, харьяа агентлагуудын дарга нарт “Төрийн байгууллагын авлига, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр цахим уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулахад холбогдох арга хэмжээг авч нийт 24 албан тушаалтан хамруулсан. Авилгатай тэмцэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг бөглөхөд анхаарах зарим асуудал, мэдүүлгийг цахимаар мэдүүлэх, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, тайлбар гаргах талаар арга зүйн сургалтыг зохион байгуулж нийт 530 гаруй албан тушаалтнуудыг хамруулж ажилласан болно.<br><br>Авлигатай тамцэх газраас зохион байгуулах “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтныг чадавхижуулах нь” зүүн бүсийн сургалтыг 2014 оны 11 дүгээр сарын 24,25-нд зохион байгуулахтай холбогдуулан сургалтын бэлтгэл ажлыг хангаж байна. Зүүн бүсийн хэмжээнд 125 эрх бүхий албан тушаалтан оролцохоор төлөвлөөд байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн суртал-чилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” нийтийн албан тушаалтны гарын авлага 30 ширхэг, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сургагч багшийн гарын авлага 30 ширхэг, Авлигтай тэмцэх газраас гаргасан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага” 200 ширгэхийг сум, агентлагийн эрх бүхий албан тушаалтан болон мэдүүлэг гаргагч нарт тараасан. /2014 оны 01 дүгээр сарын 20-25-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтаар/ Авлигатай тэмцэх газраас гаргасан “Нийтийн ашиг сонирхол гэж юу вэ?” , “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага” зэрэг гарын авлагуудыг Авлигатай тэмцэх газраас 2014 оны 06 дугаар сарын 10-нд Дорнод аймагт зохион байгуулсан сургалтаар 530 гаруй албан тушаалтнуудад тараасан. |
| 7.1.2 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэ-рийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүл-гүүдтэй харилцан санал солилцох<br><br>***Эрх зүйн үндэслэл:*** | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн га-зар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх<br><br>Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгч-дийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэ-рийн төслийг цахим хуудсан-даа байршуулсан байх | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргаж байгаа тогтоол, захирамжийг www.dornod.gv.mn; www.Dornod.khural.mn-нд байршуулж байна. Мөн захирамжийг хувийг “Иргэд хүлээн авах төв”-д байршуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагын албан тушаалтан үзэх боломжоор хангаад байна. Аймгийн хэмжээнд 2014 онд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2014 оны А/182, “Мотоциклоор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэхийг хориглох тухай”, 2014 оны А/376 “ Авто машингүй өдөр” арга хэмжээг зохион байгуулах тухай, 2014 оны А/303 “Үер усны аюулаас сэргийлэх” тухай шийдвэр гарч www.dornod.gv.mn; www.Dornod.khural.mn-нд цахим хуудсанд “Засаг даргын захирамж” гэсэн линкэд тухай бүр оруулж иргэд олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллаа. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, ил тод нээлттэй байх зарчимд тулгуурлан иргэдийг үнэн бодит мэдээ мэдээллээр хангах, тухайн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх |

| | | | |
|---|---|---|---|
| | • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br><br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 | Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх | олон нийтийн санал зөвлөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх зорилготой “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Засаг даргын дэргэдэх Тээвэр авто замын газар “Нийтийн тээврийн үйлчилгээнд мотоциклын такси үйлчилгээг хориглох тухай”, Эрүүл мэндийн газар “Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа”, Татварын хэлтэс “Татварын орлогыг нэмэгдүүлэх боломж” зэрэг сэдвээр нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна. Нийтээр дагаж мөрдөж байгаа хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг тухай бүр [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) цахим сайтад байршуулан иргэд олон нийтэд мэдээлж байна. |
| 7.1.3 | Төрийн хяналтынүйл ажил-лагааны ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлө-гөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх<br><br>Хийсэн хяналт шалгалтын-хаа дүнг олон нийтэд мэ-дээлсэн байх /цахим хууд-саар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх<br><br>Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 22 агентлагийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зорчил арилгуулах талаар аймгийн Засаг даргын удирдах ажилтны шуурхайд танилцуулж холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлж ажиллаа. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг болон ажиллах журмыг шинэчлэн боловсруулж Монголын Үйлдвэрчний эвлэлийн Дорнод аймаг дахь салбар, Либерал эмэгтэйчүүдийн Оюуны сангийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл Төрийн бус байгууллагын төлөөллийг нэмж оруулан орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад тэдний санаа бодлыг тусган ажиллаж хэвшээд байна. |
| 7.1.4 | Төсвийн орлого, түүний зар-цуулалт, гадаадын зээл, тус-ламж, түүний хуваарилалтыг олон | Тухайн жилийн төсөв*/1 дү-гээр сарын 10-ны дотор/*, өм-нөх оны төсвийн гүйцэтгэл */4 дүгээр сарын 1-ний дотор/*, дараа жилийн төсвийн төсөл */8 дугаар* | 2014 оны аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан төвсийг [www.dornod.gov.mn-д](http://www.dornod.gov.mn) хуулийн хугацаанд байршуулсан. Мөн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь байршуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, хэлтэс, албадын дарга нарт товхимол болгон хэвлэж тараасан. |

| | | | |
|---|---|---|---|
| | нийтэд тухай бүр мэдээлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br><br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл | *сарын 15-ны дотор/*-ийг цахим хуудсандаа байр-шуулах | |
| | | Жилийн эцсийн санхүүгийн тайлан */4 дүгээр сарын 1-ний дотор/*-г цахим хуудсандаа байршуулах | Аймгийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайланд хийсэн аудитын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний АРАГ-2014/153-СТА дугаартай үндэсний аудитын газрын харьяа дорнод аймгийн аудитын газрын дүгнэлтийг www.dornod.gov.mn; www.dnews.mn сайт болон мэдээллийн самбарт байршуулж иргэдэд мэдээлж ажиллаа. /Аудитын дүгнэлтийг хавсаргав./<br><br>2014 оны төсөвт орсон өөрчлөлтийг тухай бүр www.dornod.gov.mn-д байршуулсан болно. Мөн 2014 оны 11 дүгээр сарын 07-нд хуралдсан 8 дугаар хуралдаанаар тодотгол хийж өөрчлөлтийг цахим сайтад байршуулж ажиллаа. |
| | | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт */4 дүгээр сарын 1-ний дотор/*-ийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах | |
| | | Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээ-лэх */өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/* | |
| | | Концессын зүйлийн жаг-саалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бат-лагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх | Аймгийн Засаг дарга “Эх орон цэвэр байгаль” ХХК-ийн ерөнхий захирал Г.Лхагвасүрэнтэй Хогны цогцолбор үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг 16 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр байгууллаа. Монголд анх удаа хэрэгжиж буй цогцолборын нийт өртөг **123,8** тэрбум төгрөг. Дорнод аймаг байгальд ээлтэй ногоон хот болоход нэг алхам ойртож, хогны шинэ менежментийг нэвтрүүлэн**, хог хаягдал боловсруулах цогцолбор үйлдвэртэй** болох ажлын эхлэл. Мэдээллийн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим сайтад байршуулсан болно. |
| | | Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээ-лэл, концессын зүйл, гүй-цэтгэх ажил, үзүүлэх үйлчил-гээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байгаа иргэдийн жагсаалтыг www.ndaatgal.dd.gov.mn –сайтад "Таны хөтөч" гэсэн линкэд байршуулсан. |
| | | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөл-бөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах | Дорнод аймгийн Халхгол суманд Японы засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд сум дундын эмнэлэг, цэцэрлэгийн байранд 269.695 ам.долларын их засвар хийхээр гэрээ байгуулсан хэрэгжүүлж байгаа. Төсөл хөтөлбөр бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар аймгийн www.dornod.gov.mn; www.DNews.mn сайтуудад байршуулж тухай бүр мэдээлж байна. |
| 7.1.5 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл */тусгай зөв-шөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрх-лэх зөвшөөрөл/*-ийн жагсаал-тыг цахим хуудсандаа байршуулах | Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 7.1, 14.1.3, 16.2.5, Эрүүл мэндийн хуулийн 19.2, 19.11.2-т заасан эрх хэмжээний хүрээнд аймгийн Засаг дарга тусгай зөвшөөрлийг олгоод байна. Аймгийн Засаг даргын 2014 оны А/39, А56, А/134, А/135, А/138, А/201 дүгээр захирамжаар шинээр олгох болон эрх сунгасан. Аймгийн Засаг даргын 2014 оны А/31, А/238 дугаар захирамжаар үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгосон захирамжийг гаргаж аймгийн www.dornod.gov.mn сайтад байршуулж олон нийтэд мэдээлж, холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргаж байгаа захирамжийг тухай бүр www.dornod.gov.mn сайтад байршуулж байгаа. |
| 7.1.6 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг | Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/ | Дорнод аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлөөс нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны |

| | | | |
|---|---|---|---|
| | түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br><br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл | Сонгон шалгаруулалт явуу-лах талаар олон нийтийн мэ-дээллийн хэрэгслээр зарла-сан байх | зөвлөлөөс 2014 оны 05, 10 дугаар сард www.csc.gov.mn; www.dornod.gov.mn цахим сайтад байршуулан нийтэд мэдээлж ажилласан.<br>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын дагуу нөхөх үйл ажиллагааг зохион байгуулж, зарын дагуу бүртгүүлсэн нөөцөд байгаа иргэнийг тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар холбогдох байгууллагад уламжилаж байна. |
| 7.1.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсан-даа байршуулах<br><br>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх<br><br>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 15.6 тэрбум төгрөгийн 99 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төлөвлөгөөг хуулийн хугацаанд орон нутгийн сонин болох "Дорнод" сонинд хэвлүүлж мөн Сангийн яам, засгийн газрын хэрэгжүүлэгч агенлаг Худалдан авах ажиллагааны газар хүргүүлэн цахим хуудсанд нийтлүүлж, аймгийн ЗДТГ-ын болон Худалдан авах ажиллагааны албаны цахим хуудаст байрлуулсан. Мөн нийт сумдын 2014 оны Худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг нэгтгэн албаны цахим хуудаст жагсаалтаар байрлуулсан. Энэ нь сонирхсон иргэдэд аймаг, сумдын мэдээллийг нэг газраас авах боломжтой болж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, худалдан авах ажиллагааг шуурхай, оновчтой ил тод, нээлттэй зохион байгуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын "Худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь" сэдвт хэлэлцүүлгийг Худалдан авах |

| | | | |
|---|---|---|---|
| | • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл<br><br>• Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5 | | ажиллагааны албатай хамтран 2014 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулж төрийн албан хаагчдыг хамрууллаа.<br><br>Хэлэлцүүлгийн үр дүнд 2014 оныг төрийн байгууллагуудын дунд "Ил тод байдлыг хангах жил" болгон зарлаж төрийн байгууллагууд нарийвчилсан судалгаатай болох, зарим өрөө тасалгааг камержуулах, Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, болон дадлагажуулах сургалтуудыг зохион байгуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, орон нутгийн телевизэд үйл ажиллагаагаа тогтмол цагт мэдээлж ажиллахаар шийдвэрлээд байна. |
| | | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсанболон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийгцахим хуудсанд байршуулах | Тендер шалгаруулалтын үр дүн, шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийн Засгийн газрын Худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт шинжилгээний систем http://pmmis.e-procurement.mn/-д тухай бүр оруулан Худалдан авах ажиллагааны албаны цахим хуудаст байршуулах ажиллаж ирсэн. Мөн олон нийтэд мэдээллийг нээлттэй хүргэх зорилгоор хагас жилийн ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг "Дорнод" сонины 2014.06.16-ны №23 дугаарт нийтэдсэн. Жилийн эцсийн байдлаар мэдээллийг орон нутгийн сонингоор уламжлан олон нийтэд хүргэж байхаар төлөвлөж байна. Мөн Хэрлэн сумын багийн ажлын албанд байрлах самбараар дамжуулан мэдээлэл хүргэж байна. |
| | | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх | Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг сар, улирал бүр Сангийн яам болон Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Тендер зохион байгуулалтын цаг үеийн явцын мэдээг 7 хоног бүрийн даваа гаригийн аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаанд мэдээлэл хийж цаашид хэрэгжүүлж хийх ажлын талаар шуурхай хуралдааны тэмдэглэлээр үүрэгжүүлэн ажиллаж байна. 2014 оны 11 сарын байдлаар 23 удаа мэдээлэл хийж ажиллаа. /Шуурхай хуралдааны тэмдэглэлийг хавсаргав/ |

| | | | |
|---|---|---|---|
| | | Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх | Аймгийн Засаг даргын дэмжлэгээр Үнэлгээний хорооны өрөөнд хяналтын камер суурилуулж худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж нээлттэй байдлыг хангаад байна.<br><br>Иргэд, иргэний нийгмийн байгууллага, Худалдан авах ажиллагааны албаны дэргэдэх “Олон нийтийн зөвлөл”-өөс тухайн жил зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийн талаар мэдээлэл ирүүлээгүй байна. /аймгийн засаг даргын захирамжаар олгосон санхүүгийн дэмжлэгээр хийсэн хяналтын камер суурилуулсан болон бусад тайланг зурагтай хавсаргав/ |
| | | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах | Захиалагчийн 2012, 2013 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбар, цахим хуудаст байруулсан. Хөрөнгө оруулалтын бодит мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилгоор төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийн талаар 31 минутийн телевизийн нэвтрүүлэг бэлтгэж орон нутгийн “Мижи” ТВ, “Шинэ суваг” телевизээр тус тус 2 удаагийн давтамжтайгаар нэвтрүүллээ.<br>Худалдан авах ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй өрсөлдөх тэгш боломжийг хангах, оролцогчдыг чадваржуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газартай хамтран тендерт оролцогч аж, ахуй нэгжүүдэд зориулсан “худалдан авах ажиллагаанд хэрхэн амжилттай оролцох вэ” сэдэвт сургалтыг зохион байгуулж 20 гаруй аж, ахуй нэгж байгууллага оролцлоо. Мөн аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран “Тендерийн санал боловсруулах нь” сургалтыг зохион байгуулж 15 аж ахуй нэгж оролцлоо. Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох А3 сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 222 хамрагдсанаас 114 хүн тэнцэж гэрчилгээтэй болов. / 31 минутын телевизийн нэвтрүүлгийн CD-г хавсаргав/ |
| | | Тендерийн үнэлгээний хо-рооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн хол-боод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөл-лийг оролцуулсан байх | |
| 7.1.8 | Албан хаагч бүрийн ажил үүргийн | Төрийн албан хаагч нэг бү-рийн ажил үүргийн хуваарь, ажлын | Аймгийн нэгдсэн сайт www.dornod.gov.mn-нд нийт албан тушаал болон эрхлэх асуудлын чиг үүргийг нээлттэй мэдээлж |

| | | | |
|---|---|---|---|
| | хуваарийг тодорхой болгох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 | байрны тодорхойлол-тыг баталж мөрдүүлсэн байх<br><br>Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээл-лийг цахим хуудсаараа нээлттэй болгох | ажиллаж байна. 2014 оны 10 сараас эхлэн нийт албан хаагчдын зураг,эрхлэх чиг үүргийн хамт шинэчилж байна. Төрийн албан хаагчийн хариуцлагын дээшлүүлэх ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн болон байгууллагын нууцыг хамгаалах журам, Байгууллагын нууцад хамаарах баримт бичиг, биет зүйлийн жагсаалт, нууц баримттай харьцах эрх бүхий албан тушаалтнуудыг баталсан аймгийн Засаг даргын 2014 оны 274 дүгээр захирамжаар батлан гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. |
| 7.1.9 | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6.1.7, 6.1.13;<br><br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.6.3 | Тодорхой төрлийн үйл ажил-лагааны хэрэгжилт, явц бай-далд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллa-гаар гүйцэтгүүлсэн байх<br><br>*/1 ба түүнээс дээш/*<br><br>Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүл-сэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх<br><br>Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх | Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, ололттой болон дутагдалтай ажлыг гаргаж ололттой ажлыг сурталчилан түгээн дэлгэрүүлэх, дутагдалтай ажлыг сайжруулах арга хэмжээг авах зорилгоор хэрэглэгчдийн үнэлгээний судалгааг хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага хүний нөөцийн хүчин чадал зэргийг сонгон шалгаруулалтыг аймгийн Засаг даргын 2014 оны А/144 дугаар захирамжийн дагуу зөвлөх үйлчилгээний баг сонгон шалгаруулах нээлттэй тендер зарлаж, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн тэргүүн Д.Бужингээр ахлуулсан баг шалгарч, гэрээ байгуулан үйл ажиллагааг эхлэж 14 сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг аваад байна. Үйл ажиллагааны талаар тухай бүр орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж иргэдэд хүргэж байна.<br><br>Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны явцын тайланг хавсаргав. |
| 7.1.10 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг | Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх | 2007 оны 6 сараас эхлэн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хөрөнгө орлогын мэдүүлэг хадгалах хамгаалах, хяналт тавих, Авлигтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөлтыг хариуцан |

| | | | |
|---|---|---|---|
| | хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх | ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх | ажиллаж байна. Анх эрх бүхий албан тушаалтнаар томилсон шийдвэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2008 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06 тоот тушаалаар хариуцан хийсэн. ЭБАТ-ын 30, нууцйэ 10 хувийн нэмэгдэл авдаг. Ажлын байрны тодорхойлолт, томилсон тушаалын хуулбарыг хавсаргав. ЭБАТ-н зохион байгуулж байгаа бүх сургалтад хамрагдсан. |
| | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх | |
| 7.1.11 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• НАНБХАСЗАСЗ УСТ хуулийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; | Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх | Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх ажлын хүрээнд "Судалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн ухаалаг төрийн бодлогыг сум, агентлаг, бүх төрийн байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллаж тайлагнаж байна" гэсэн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж ажиллаа.<br><br>Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн тусгай шаардлага болон үндсэн хэрэгжүүлэх зорилтод "Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байж үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангаж ажиллах, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, Нууц хадгалах, Ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй, ёс зүйг чанд сахиж ажиллах" заалтыг оруулж шинэчилсэн.Анх ёс зүйн дүрмийг шинэчлэн бүх албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулж албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргасан байгаа. |
| | | Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх/албан хаагчдад танилцуулсан байдал/ | |
| | | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /*тогт-мол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуу-дангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м*/-ийг бүр-дүүлсэн байх | |
| | | Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьд-чилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах | |
| | | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийд-вэр | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын |

| | | | |
|---|---|---|---|
| | | /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуу-лах | 2014–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, дорнод аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж хэрэгжилтэд нь хяналт тавих зорилгоор Төрийн байгууллагын вэб сайтад" аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2014 оны 5 сар, 9 сард дүн шинжилгээг хийсэн. 2014 оны 04 сард дүн шинжилгээ хийсэн дүн болон ажил сайжруулах талаар 2 удаа албан тоот хүргүүлж цахим сайтыг сайжруулах талаар сум бүр орон нутгийн онцлогт тохируулан арга хэмжээ авч ажилласан байна. Аймаг сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийг цахим сайтад байршуулан иргэд, албан тушаалтнуудыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br><br>Аймгийн Засаг даргын Тамгын газраас ИТХ, Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргасан бодлогын шийдвэрийн эмхтгэн улирал бүр "МЭДЭЭЛЭЛ" сэтгүүл гаргад сум болон агентлагт хүргүүлж иргэд хүлээн авах төвд тавьж иргэдэд мэдээлэл авах боломжоор хангаж байна. /Удирдамж болон 2014 оны 5,9 дүгээр сард дүн шинжилгээ хийсэн дүнгийн хүснэгт, сумдад чиглэл өгсөн албан тоотыг хавсаргав/ |
| | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хууль-чилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах | |
| | | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | Төлбөр, хураамж авсан үйл ажиллагааг явуулдагүй болно. |
| 7.1.14 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрч-лийн талаарх | Хууль тогтоомжоор тогтоо-сон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх<br><br>Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хү-лээн авах нөхцөлийг бүр-дүүлсэн байх (утас, хайр-цаг, санал хүсэлтийн | Дорнод аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, харъяа агентлагууд нь "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, харъяа агентлагууд нь иргэдийн өргөдөл, гомдлыг х лээн авах, б ртгэх, хяналт тавих, шийдвэрлэх, д гнэх, ард иргэдээс ир лсэн санал, х сэлтийг судлан ажилдаа тусгах, иргэдийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг ханган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2005 оны 243 дугаар захирамжаар "Иргэдийн өргөдөл, гомдлыг х лээн авч шийдвэрлэхтэй |

| | | | |
|---|---|---|---|
| | мэдээллийг хүлээн авч шалгах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br><br>• Мэдээллийн ил тод бай-дал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br><br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг со-нирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;<br><br>• Иргэдээс төрийн байгуул-лага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр | дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)<br><br>Үйлчилгээ, захидал харил-цааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан ту-шаал, ажиллах журам, ха-рилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээл-лийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах<br><br>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хуга-цаанд мэдээлсэн байх<br><br>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг ба-гасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн аж-лын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/ | холбогдсон журам"-ыг батлан гаргаж, б х сум, агентлаг, байгууллагууд хэрэгж лж, аймгийн Засаг даргын "Журам батлах тухай" 2008 оны 73 дугаар захирамжийн дагуу амьдралын гачигдалтай иргэдэд мөнгөн тусламж з үлдэг.<br><br>Аймгийн Засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/368 тоот захирамжаар иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, төрийн байгууллага, иргэд хоорондын харилцаа, холбоог сайжруулах, төрийн албан хаагчдыг хуулинд заагдсан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газарт "НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233" дугаарын утсыг ажиллуулж байна. Иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлын талаар долоо хоног бүрийн 5 дахь өдөр Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын шуурхай хуралд танилцуулж хэрхэн шийдвэрлэх талаар долоо хоног б рийн Даваа гаригт байгууллагуудын удирдах ажилтнуудын "Шуурхай" хуралдаанд холбогдох газарт шуурхай хуралдааны тэмдэглэлээр үүрэгжүүлэн шийдвэрлэлтийн талаар эргэж танилцуулан ажиллаж байна.<br><br>Иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг ажлын 5 хоногт багтааж шийдвэрлэж, тухайн иргэнд хариуг мэдээллэн ажиллаж байна. Нээлттэй утас ажиллаж эхэлснээс хойш нийт 1816 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлж байна. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2014-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийг хангах төрөөс иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай хүргэх, иргэдээс төрийн байгууллагад гаргасан санал хүсэлтэд шуурхай хариу өгөх зорилгоор "НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233" дугаарын утас, "Иргэд хүлээн авах төв", удирдах ажилтнуудыг ажиллуулах удирдамжийг аймгийн Засаг даргаа батлуулан удирдах ажилтнуудыг хуваарийн дагуу нээлттэй устсанд ажиллуулж иргэдээс ирсэн санал хүсэлтийг газар дээр шийдвэрлж ажиллаж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг бүртгэх түүний |

| | | | |
|---|---|---|---|
| | зүйлийн 3 дахь хэсэг | | шийдвэрлэлтэд хяналт тавих цахим системийг “Уран аяа” ХХК-тай гэрээ байгуулан цахим сайт хийлгэн өргөдөл гомдлын шийдвэрлэл, нээлттэй утасны санал, төрийн байгууллагад хүргэх албан тоотыг цахимаар хүргэж эхлээд байна. http;//70582233.mn/ сайтаас харах боломжтой. |
| 7.1.1 7 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гарга-сан шийдвэрийг биелүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;<br><br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн бие-лэлт, зохион байгуулсан арга хэмжээ<br><br>АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөх-цөлийг арилгуулахаар хүр-гүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэм-жээ<br><br>АТГ-аас зөрчил арилгуула-хаар хүргүүлсэн албан бич-гийн биелэлт, зохион бай-гуулсан арга хэмжээ<br><br>АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт<br><br>Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг | Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 3.2-д заасны дагуу Боловсролын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Байгаль орчны газар, Худалдан авах ажиллагаа, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс зэрэг байгууллагуудын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтад “Нууцын баталгаа” гаргуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангасан. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамж, 2014 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу тус аймагт 2014 оны 06 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд Авилгатай тэмцэх газраас ажиллаад зөрчил арилгуулах тухай 2014.07. ний өдрийн 01/5909 албан тоотын дагуу “Хуулийг хэрэгжүүлэх ажлын талаар авах арга хэмжээний тухай” Боловсролын газар 5/2508, Эрүүл мэндийн газар 5/2515, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 5/2510, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 5/2514, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар 5/2512, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс 5/2516, Байгаль орчны газар 5/2511, Тээвэр, авто замын газар 5/2509, Худалдан авах ажиллагааны алба 5/2507, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс 5/2513 тус бүр албан тоотыг хүргүүлж ажиллалаа. Аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд томилогддог 13 албан хаагчийг “Ажлаас чөлөөлөх тухай” 2014 оны Б/37 дугаар захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны Б/51 дүгээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх<br><br>АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагд-сан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийт-гэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон ний-тэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ | тушаалыг тус тус гаргаж холбогдох материалыг хуулийн дагуу бүрдүүлэн 2014.08.01-ний өдрийн 1/2597, 2/2604 албан тоотоор Авлигатай тэмцэх газарт урьдчилсан мэдүүлгийг хүргүүлж ажилласан. Төрийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх, иргэдийн саналыг тусгах, гарч байгаа шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн 13 сумын засаг даргын эрх хэмжээний хүрээнд гаргаж байгаа захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын тушаалын эрх зүйн үндэслэл болон үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж арга зүйн удирдлагаар хангаж ажиллаа. Захирамж тушаал хянахдаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох бүрт болон захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг бэлтгэх, оролцохын өмнө буюу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдол бүрд тус тус “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг маягтын дагуу цаг хугацаанд нь бөглүүлж авах, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” заалтын дагуу урьдчилсан мэдүүлгийг хянуулж томилох зэрэг хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангаж ажиллахыг анхааруулж бүх сумдад албан тоот хүргүүлж ажиллаа. /Сумдад хүргүүлсэн албан тоотын хувийг хавсаргав/ Төрийн албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэж журмын дагуу 2014 онд аймгийн хэмжээнд 38 албан хаагчдад хуулийн дагуу арга хэмжээ авсан байна.<br><br>Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийн удирдах ажилтны шуурхай болон аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод мэдээллийн цагаар танилцуулж ажиллаж байна. |

| Дэд хэсэг | Бусад ажлын талаар | | |
|---|---|---|---|
| 7.2.1 | Авлигын эсрэг соён гэгээрүү-лэх, авлигатай тэмцэх, урьд-чилан сэргийлэх арга хэм-жээг боловсруулж хэрэгжүү-лэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br><br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; | Авлигын эсрэг үйл ажилла-гааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх<br><br>Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх<br><br>Хэрэгжилтийн тайланг тогт-сон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх<br><br>Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор “Дорнод аймгийн 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж авлигатай тэмцэх газарт хүргүүлэн санал авсан. Авлигатай тэмцэх газарт хянуулсан төлөвлөгөөний төслийг 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдөр аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан хурлын тэмдэглэл, төлөвлөгөөний хувийг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Аймгийн 14 сумд орон нутгийн онцлогт тохирсон төлөвлөгөөг боловсруулж ажиллаж байгаа. Аймгийн авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг www.dornod.gov.mn-д байршуулсан байгаа.<br><br>Аймгийн хэмжээнд ил тод нээлттэй байдлыг хангах Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд санал боловсруулж тусгах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/67 дугаар захирамжаар байгуулж ажлын хэсгийг хуралдуулан аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2014 оны төлөвлөгөөнд хийх ажлыг төсвийн хамт оруулсан. Хуулийг хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл бэрхшээл болон хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах саналыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн болно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6. дахь заалтыг хэрэгжүүлэхэд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.3 дахь заалт хугацааны хувьд зөрчигдөж байгаа тул сумдын Засаг дарга нарын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг цахим шуудангаар хүлээн авч нэн даруй хариуг ирүүлж байх нөхцөл боломжийг хангах. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг төрийн захиргааны ТЗ-05-аас дээшхи албан тушаалтнуудыг хуулийн үйлчлэлд хамруулж" мэдүүлэг авах.<br><br>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахад түр томилогдож буй албан тушаалтан хамаарч, хянуулсан гэдгээр удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, төрийн албаны шалгалт өгөөгүй иргэдийг шууд томилох зэрэг хуулийн хийдлийг гаргаж байгаад анхаарч туршилтын хугацаагаар томилогдох үед хянуулах зохицуулалтыг өөрчлөх. /Төрийн албаны зөвлөлөөс шалгалт өгсөн өгөөгүй тухай албан бичгийг гаргуулж байх/<br><br>Нийтийн албан тушаалтан байгууллага, нэгж дотор өөрчлөгдөх үед хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах зохицуулалтыг хөнгөвчилж, журамд өөрчлөлт оруулах зэрэг саналыг хүргүүлж ажиллаа. |
| 7.2.2 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, ху-вийн хэвшлийн байгууллa-гаас гаргасан санал санаа-чилга /уриа, уриалга, мэдэг-дэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал | Төрийн бус байгууллагын явцын ажлын тайланг хавсаргав. |
| | | Удирдах албатушаалтнуу-дын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал | Төлөвлөгөөнөөс гадуур хийсэн ажлын тайланг хавсаргав. |
| | | Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 2,0 сая төгрөг тусгасан болно. /Сургалт сурталчилгаа олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдаж байна./ |

| | | | |
|---|---|---|---|
| | | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ | Байгууллагын үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар үнэлүүлж байгаа бөгөөд гэрээ болон хийх ажлын шийдвэрийг хавсаргав. Одоогоор дүгнэлт эцэслэн гараагүй байна. |
| | | Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ | Эдгээр тохиолдол гараагүй болно. |
| | | Шүүхээр шийдэгдсэн<br><br>Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Э.НАНДИН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЖАРГАЛ

ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ГАДУУР АЙМГИЙН
УДИРДЛАГААС САНААЧЛАН ХИЙСЭН АЖИЛ

Аймгийн Засаг даргын 2014-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тулгуурлан аймгийн нийгэм, эдийн засгийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны ээлжит 5 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор 3 бодлогын 14 бүлгийн хүрээнд нийт 159 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.Төрийн байгуулалтын зорилтын хүрээнд:

1.1.1 Төр засгийг иргэдэд нээлттэй болгох цогц арга хэмжээний хүрээнд "Иргэдтэй уулзах өдөр" арга хэмжээг сум, багийн түвшинд улирал бүр зохион байгуулж ажиллана.

1.1.2 Иргэд олон нийтийн санал санаачлагыг нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж төр засгийн бодлого шийдвэрт тусгаж ажиллана.

1.1.3 Орон нутагтаа төр-иргэний нийгмийн байгууллага, төр-хувийн хэвшлийн байгууллагуудын түншлэлийг хэрэгжүүлж ажиллана.

1.1.4 Сумдад иргэний танхим, Нээлттэй утас ажиллуулна.

1.1.5 Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд сум, агентлагуудын тайланг хэлэлцүүлэн, зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажиллана гэж оруулсан.

Орон нутгийн төр, захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах, тэдгээрийн йл ажиллагааны мэдээллийг сонсож, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, р д нг дээшл лэх, тулгамдаж буй асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 55 дугаар захирамж гарч долоо хоног б рийн Даваа гаригт байгууллагуудын удирдах ажилтнуудын "Шуурхай" хуралдааныг хийж хэвшээд байна. Одоогийн байдлаар 43 удаа шуурхай хуралдаж дунджаар 32 удаагийн тэмдэглэлээр 120 рэг даалгаврыг албажуулан холбогдох агентлагуудын удирдлага, албан тушаалтнуудад өгч биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Шуурхай хуралдаанаар өгсөн үүргийг хэрэгжүүлэх албан хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын А/104 дүгээр захирамжаар "Төр захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын удирдах ажилтны шуурхай хуралдаан зохион байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан, А/103 дугаар захирамжаар "аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, мэргэжилтэн, сумын Засаг дарга, агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгжийн дарга нарын гадаад, дотоодод томилолторр ажиллах журам"-ыг шинэчлэн батлаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, худалдан авах ажиллагааг шуурхай, оновчтой ил тод, нээлттэй зохион байгуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас "Худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь" сэдэвт хэлэлцүүлгийг Худалдан авах ажиллагааны албатай хамтран 2014 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулж төрийн албан хаагчдыг хамруууллаа.

Хэлэлцүүлгийн үр дүнд 2014 оныг төрийн байгууллагуудын дунд "Ил тод байдлыг хангах жил" болгон зарлаж төрийн байгууллагууд нарийвчилсан судалгаатай болох, зарим өрөө тасалгааг камержуулах, Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, болон дадлагажуулах сургалтуудыг зохион байгуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, орон нутгийн телевизид үйл ажиллагаагаа тогтмол цагт мэдээлж ажиллахаар шийдвэрлээд байна.

Аймгийн Засаг даргын тамгын газраас сар бүрийн эхний долоо хоногт орон нутгийн төр захиргааны байгууллага болон агентлаг хэлтсүүдэд хийгдсэн ажил, Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2014 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудын явц байдлыг мэдээлэх зорилгоор "Орон нутгийн удирдлагын цаг" нэвтрүүлгийг сэтгүүлчид хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 2014 оны 5 дугаар сараас эхлэн сар бүр зохион башуулж ажиллаж байна.




Төр засгийн болон аймаг орон нутгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, төр иргэний уялдаа холбоог сайжруулан, иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улирал бүр зохион байгуулдаг "Иргэдтэй уулзах өдөр" арга хэмжээг аймгийн төвийн Хэрлэн сумын 10 багт 3,6 дугаар саруудад 2 удаа зохион байгууллаа.







"Иргэдтэй уулзах өдөр"-өөр Засаг даргын дэргэдэх агентлаг хэлтсүүд үйл ажиллагаагаа сурталчлах болон байгууллагын зарим үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаа.

Халхгол, Матад, Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун сумдад зохион байгуулсан байна. Иргэдтэй уулзах өдөр арга хэмжээний үеэр аймгийн засаг дарга С.Ганбат 2014 онд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын явц, цаг үеийн ажлуудын талаар иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтсүүд өөрсдийн үйл ажиллагаа сурталчилж, иргэдэд нэг цэгээс үйлчилгээ үзүүлж ажиллав. "Иргэдтэй уулзах өдөр" арга хэмжээг 2014 оны 11 дүгээр сарын байдлаар 8 суманд зохион байгуулаад байна. Үлдсэн 6 сумдад 11 дүгээр сард зохион байгуулна.






Аймгийн Засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/368 тоот захирамжаар иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, төрийн байгууллага, иргэд хоорондын харилцаа, холбоог сайжруулах, төрийн албан хаагчдыг хуулинд заагдсан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газарт “НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233” дугаарын утсыг ажиллуулж байна. Иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлын талаар долоо хоног бүрийн 5 дахь өдөр Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын шуурхай хуралд танилцуулж хэрхэн шийдвэрлэх талаар долоо хоног б   рийн Даваа гаригт байгууллагуудын удирдах ажилтнуудын “Шуурхай” хуралдаанд холбогдох газарт шуурхай хуралдааны тэмдэглэлээр үүрэгжүүлэн шийдвэрлэлтийн талаар эргэж танилцуулан ажиллаж байна.

Иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг ажлын 5 хоногт багтааж шийдвэрлэж, тухайн иргэнд хариуг мэдээллэн ажиллаж байна. Нээлттэй утас ажиллаж эхэлснээс хойш нийт 1816 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлж байна.






Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2014-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийг хангах төрөөс иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай хүргэх, иргэдээс төрийн байгууллагад гаргасан санал хүсэлтэд шуурхай хариу өгөх зорилгоор “НЭЭЛТТЭЙ УТАС – 7058-2233” дугаарын утас, “Иргэд хүлээн авах төв”, удирдах ажилтнуудыг ажиллуулах удирдамжийг аймгийн Засаг даргаа батлуулан удирдах ажилтнуудыг хуваарын дагуу нээлттэй устсанд ажиллуулж иргэдээс ирсэн санал хүсэлтийг газар дээр шийдвэрлж ажиллаж байна.







/Чойбалсан хөгжил ОНӨҮГ-н дарга/ /Боловсролын газрын дарга/

Төр засгийн бодлого шийдвэр, Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрт иргэдийн санал, бодлыг тусгах, тэдний санал, хүсэлтийг шийдвэр гаргагчдад хүргэх зорилгоор Баяндун, Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Матад, Сэргэлэн, Халхгол, Хэрлэн, Чойбалсан, Чулуунхороот зэрэг нийт 11 суманд "Иргэний танхим", Баяндун, Баян-Уул, Булган, Гурванзагал, Матад, Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн, Цагаан-Овоо зэрэг нийт 9 суманд "Нээлттэй утас"-ыг нээн орон нутгийн онцлогт тохирсон журам боловсруулан хэрэгжүүлэх ажлыг нутагд дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг бүртгэх түүний шийдвэрлэлтэд хяналт тавих цахим системийг "Уран аяа" ХХК-тай гэрээ байгуулан цахим сайт хийлгэн өргөдөл гомдлын шийдвэрлэл, нээлттэй утасны санал, төрийн байгууллагад хүргэх албан тоотыг цахимаар хүргэж эхлээд байна.




Мөн төрийн байгууллага хооронд гарч байгаа албан тоотын аймгийн 14 сумын Засаг даргын дэргэдэх агенлага, хэлтэс, газар, алба болон орон нутгийн өмчид үйлдвэрийн газарт нэгэн зэрэг цахимаар хүргэх боломж бүрдээд байна.







Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2014−2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, дорнод аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж хэрэгжилтэд нь хяналт тавих зорилгоор Төрийн байгууллагын вэб сайтад" аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2014 оны 5 сар, 9 сард дүн шинжилгээг хийсэн. 2014 оны 04 сард дүн шинжилгээ хийсэн дүн болон ажил сайжруулах талар 2 удаа албан тоот хүргүүлсэн. /Цахим сайтад хийсэн дүн шинжилгээний удирдамж, зөвлөмж албан тоотыг хавсаргав/

Аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг, сумдад ёс зүйн хороод ажиллаж, аймгийн ЗДТГ-ын ёс зүйн хороо, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл тэднийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Бүх байгууллагууд Ёс зүйн дүрмийг төрийн албан хаагчдад танилцуулж баталгаа гаргаж хувийн хэрэгт хийсэн. "Төрийн захиргааны албан хаагчийн ёсз йн д рэм", "Төрийн захиргааны албан хаагчийн ёсз йн д рмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёсз йн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. Ёс зүйн хороодын ажлыг төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд чиглүүлэн, ажлыг нь тогтмолжуулахад анхаарч, журамд заасны дагуу ёс зүйн зөрчлийн талаар бүх байгууллагуудаас хагас, бүтэн жилийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд мэдээ авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлд мэдээлж ажиллаж байна.

Төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолтод төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, архи согтууруулах ундааг ажлын цагаар болон ажлын байранд хэрэглэхгүй байх,авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж ажиллахыг тусгай заалт болгон оруулж албан хаагч бүр чанд мөрдөн ажиллаж байна. / 1-2 төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолотыг хавсаргав.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлаг хангах иргэдэд төрийн үйлчилгээг хэрхэн хүргэж байгаад хөндлөнгийн хяналт шалгалт хийх багийн төрийн бус байгууллагаар хийлгэх гэрээ байгуулан үйл ажиллагаагд дүгнүүлсэн.

Хөндлөнгийн баг аймгийн 14 сум 22 агентлагт хяналт шалгалтыг зохион байгуулж аймгийн Засаг даргын 2012 оны А/114 дүгээр захирамжаар "2012 онд ажилласан хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр багийн дүнгийн мөрөөр авах арга хэмжээ"-ний захирамжийг гаргаж сум, агентлагт хүргүүлж ажиллаа.





Худалдан авах албанаас 2014 оныг "Ил тод байдлыг хангах жил" болгон зарлаж энэ ажлын хүрээнд аймгийн Засаг даргын дэмжлэгээр Үнэлгээний хорооны өрөөнд хяналтын камер суурилуулж худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай байх зарчимыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.

Худалдан авах ажиллагааны талаар нарийвчилсан судалгаатай болох, цахим тендерийг эхлүүлэх, мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалтуудыг зохион байгуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах , ТВ-д худалдан авах ажиллагааны мэдээллийн тогтмол цагтай болох зэрэг олон ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны албанаас энэ онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр санхүүжигдэх нийт 6,8 тэрбум төгрөгийн 78 төсөл арга хэмжээг үнэлгээний хороодоор дамжуулан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН Э.НАНДИН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА Д.ЖАРГАЛ